



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 21 өдөр

Дугаар 188

Жавхлант

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.5, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах шаардлагатай техник тоног төхөөрөмжийг бэлтгэх зорилгоор чанарын өндөр үзүүлэлттэй DRON худалдаж авахад шаардагдах 4.500.000 (дөрвөн сая таван зуун мянган) төгрөгийг зарцуулсугай.
2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Гамшгийн эрсдэлийг бууруулах зардлаас зарцуулахыг нягтлан бодогч (Уранбайгаль)-д зөвшөөрсүгэй
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Шаравгаваа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ  ГЭНХЗАЯА

